



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 12 сарын 25 өдөр

Дугаар 5/78

Чингис хот

Г.Нэргүйбаатарт сахилгын
шийтгэл ногдуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Авлигын эсрэг хуулийн 13 дугаар зүйлийн 13.8.2, Засгийн газрын 2018 оны 258 дугаар тогтоолын 1.1, 01 тоот албан даалгаварын 2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1. Авлигатай тэмцэх газрын 2019 оны 05/10871 тоот албан бичгээр Биеийн тамир спортын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Нэргүйбаатар нь Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь заалтыг зөрчсөн нь тогтоогдсон тул түүний үндсэн цалинг 1 сарын хугацаанд 30 хувиар бууруулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2. Албан үүргээ холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд биелүүлж ажиллахыг Г.Нэргүйбаатарт үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс /Г.Лхагвахатан/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Н.ГАНБЯМБА